



Г БАЯНТУМЭН СҮМҮН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА П.ГУНГААЦЭРЭН ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.19 № 500

таний -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд 7
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянтуумэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Баянтуумэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020 Төрийн аudit. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аudit. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аudit. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Баянтүмэн сумын Монгол ардын намын Баянтүмэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянтүмэн сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр гурван хуудас хавсаргав.


Хувийг: "Баянтүмэн сумын Монгол ардын намын хороо"-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд


Хавсралт 3 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



Дорнод аймгийн Баянтуумэн сумны
Монгол Ардын Намын хорооны
2024 оны 06 дугаар сарын ...-ны өдрийн
...р хуралдааны тоот тогтоолын хавсралт



**ДОРНОД АЙМГИЙН БАЯНТУМЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНЫ 2024 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

БАЯНТУМЭН СУМ

БАЯНТУМЭН СУМ

1. Нийгмийн салбарт

- 1.1** Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаварын биелэлтийг хянадаг болно.
- 1.2** Баянтумэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах хогын цэгийг хашаажуулах.
- 1.3** Засаг даргын Тамгын газрын барилга шинээр барих.
- 1.4** Сумын төвд 1км асфальтан хучилттай замыг үргэлжлүүлэн барих.
- 1.5** Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шат дараалалтайгаар шинэчилнэ.
- 1.6** Төрийн албан хаагч, багш ажилчдын нийгмийн баталгааг дэмжих, орон сууцжуулах
- 1.7** Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зэрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 1.8** Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж хүүхдийн иж бүрэн цогцолбор “Баясгалант” парк байгуулж орчны стандартыг мөрдүүлж, хүүхэд аюулгүй орчин, хяналтыг сайжруулна.
- 1.9** Сумын төвийн хорооллуудын гудамжны гадна гэрэлтүүлгийг үе шаттайгаар гэрэлтүүлэх.
- 1.10** Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг бодлогоор дэмжих
- 1.11** 2,3 -р багт үүрэн холбоог сайжруулах станц барих.

2. Эрүүл мэндийн салбарт

- 2.1** Хүн эмнэлгийн тоног, төхөөрөмжийг нэмэгдүүлэх.
- 2.2** Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх, бодлогыг дэмжиж ажиллах.
- 2.3** Ахмад настан, хүүхдийг эмчлүүлэх таатай орчин нөхцлийг бурдүүлэхийн зэрэгцээ хүн эмнэлгийг түшиглэн суурь өвчтэй хүүхдийг сувилан эрүүлжүүлэх сувилал байгуулна.
- 2.4** Эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөрийг дэмжин ажиллах.

3. Боловсрол, Соёл урлаг

- 3.1** Сургуулийн спорт заал шинээр барих.
- 3.2** Сургуулийн дотуур байрны их засвар.
- 3.3** Сургалтын орчныг сайжруулах зорилгоор дотор их засвар.

- 3.4** Соёлын төвд хөгжим,техник хэргэслийг шинэчлэх,соёл урлагын салбарын хөгжлийг дэмжих, өв соёл, сумын дэд хөтөлбөрийг дэмжин ажиллах.
- 3.5** Орон нутгийн судлах танхимиyg тохижуулах, өргөжүүлэх.
- 3.6** Орон нутгийн номын сангийн уламжлалт үйлчилгээг чанаржуулах, номын баяжилт хийх.
- 3.7** Хөдөөгийн багуудад гэр цэцэрлэг,өдөр өнжүүлэх төвийг ажиллуулах
- 3.8** Монголын нүүдлийн соёл,орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнийг дэмжин ажиллах.

4. Хөдөө аж ахуй

- 4.1** Бүх багуудад ундны усны худаг гаргах, малчдын санал, хүсэлт, иргэдийн оролцоонд тулгуурлан гүний худагуудыг гаргах , бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх.
- 4.2** Малжуулах төсөл хэрэгжүүлэх. /Хөдөөгийн багийн малчид/
- 4.3** Шинэ хөдөө хоршоог дэмжин ажиллах, фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх, эдийн засаг эрх зүйн нэн таатай орчныг бүрдүүлэх.
- 4.4** “Органик” хөдөө аж ахуйг хөгжүүлэх төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх,Сумын төвийн өрхүүдийг бодлогоор дэмжиж өвлийн хүлэмжийн аж ахуйг шинээр байгуулах.
- 4.5** Тахианы аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх.
- 4.6** Өвсний нөөцийн агуулахыг бүх багт байгуулна.
- 4.7** Малын үүлдвэр угсааг сайжруулах, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжин хөгжүүлэх.
- 4.8** Мал эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах.
- 4.9** Арьс, шир боловсруулах цех байгуулах.
- 4.10** Сүү боловсруулах цех байгуулах.

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

- 5.1** “Жижиг дунд үйлдэрийг орон нутгийн онцлогт тохируулан, иргэдэд тэгш хүртээх, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.
- 5.2** Хүн,амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин орлогыг тогтвортой нэмэгдүүлж, жижиг дунд бизнесийг өрх, гэр бүлд нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

**БАЯНТУМЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРОО**

